

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ” ТӨХХК -ИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

“Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” /ХХНОБ/ ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ХХНОБ ТӨХХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 93,5%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. ХХНОБ ТӨХХК-ийн 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
16	13	-	1	1	1	-	-	90,6%

2.2. Сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
4	2	-	-	2	100%

2.3. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	Хугацаа болоогүй	
Төсөв/гүйцэтгэл	9	7	-	-	-	2	100,0
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	5	5	-	-	-	-	100,0
бусад	8	8	-	-	-	-	100,0
Нийт	22	20	-	-	-	2	100,0

2.4. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс						Биелэлтийн хувь
		100%	70%	50%	30%	0%	хамааралгүй	
Нийт	35	12	2	1	1	1	18	83,5%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

ХХНОБ ТӨХХК нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) ХХНОБ ТӨХХК-ийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалын хэрэгжилт, Шилэн дансны хөтлөлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **93,5%-тай** байна.
- 2) “Чингис хаан” ОУНБ 2025.06.30-ны өдрийн байдлаар нийт 8,375 нислэг, 4,619 тн карго ачаа хүлээн авч, 1,063,240 зорчигчид үйлчилсэн байна. Энэ нь 2024 оны мөн үетэй харьцуулахад карго ачааны тоо 0,4%, нислэг 5%, зорчигч 13%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- 3) “Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд нийт 42 удаагийн нислэгээр Монгол Улсаас гадаад улсад хийх болон гадаад улсаас Монгол улсад хийх төрийн өндөр дээд хэмжээний айлчлал, олон улсын хурал, форумын оролцогчид зэрэг албаны нийт 834 тусгай үйлчлүүлэгч,

- үүнээс 683 зорчигч, 151 угтагч, үдэгчдийг “Чингис хаан” ОУНБ-д угтан авах, үдэн гаргах үйлчилгээг үзүүлжээ.
- 4) Тайлант хугацааны гүйцэтгэлээр Хүндэт зочны танхимын үйлчилгээний орлого 488.0 сая төгрөг, ногдол ашгийн орлогоос 13,360.8 сая төгрөг, хүүгийн болон бусад орлогоос 695.9 сая төгрөг, нийт 14,544.8 сая төгрөгийн орлого орж, нийт төлөвлөсөн орлогыг **1,910.8 сая төгрөг** буюу 115 хувиар давуулан биелүүлсэн байна.
- 5) Хамтарсан компанийн үйл ажиллагааны орлого 2025.06.30-ны өдрийн байдлаар **75.2 тэрбум төгрөг** ба өнгөрсөн оны мөн үеэс (65.7 тэрбум төг) 14%-иар өссөн. Концессын төлбөр 13.9 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оны мөн үеэс (6.6 тэрбум төг) 2.1 дахин, төсөвт төлөх албан татвар, төлбөр, хураамжийн дүн 23.5 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс (14.1 тэрбум төг) 1.6 дахин өссөнөөр нийт улсын төсөвт төлөх төлбөрийн дүн **37.4 тэрбум төгрөгт** хүрсэн үзүүлэлттэй байна.
- 6) 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжүүдээс Чингис хаан” ОУНБ-ыг өргөтгөх, цаашид олон улсын агаарын ачаа тээврийн транзит төв болгон өргөжүүлэх чиглэлээр судалгааны ажлыг эрчимжүүлж, хөрөнгө оруулагч талд тавьж шийдвэрлүүлэх, АНУ руу шууд нислэг үйлдэхтэй холбоотой хийгдсэн TSA-ийн шалгалтаар “Чингис хаан” ОУНБ-д одоо хэрэглэгдэж байгаа, үзлэг шалгалтын зарим төхөөрөмжүүдийг шинэчлэх зөвлөмж өгсөний дагуу шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг худалдан авах санхүүжилтийг шийдвэрлэн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах ажлууд хэрэгжсэн байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. АНУ руу шууд нислэг үйлдэхэд “Чингис хаан” ОУНБ-ын зүгээс авч хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд “Чингис хаан” ОУНБ-д шаардлагатай төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах ажлыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх;
2. Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах, болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын хавсралтаар Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээг 5 хэсгийн 98 нээлттэй мэдээллээс өөрт хамаарах асуудлыг shilen.gov.mn сайтад тайлагнаж ажиллахаар шийдвэрлэсний дагуу тус сайтад бүртгүүлэн холбогдох мэдээллийг тогтоосон хугацаанд нь байршуулах;
3. Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн болон хяналт-шинжилгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд МИАТ ТӨХК болон яам, ИНЕГ, ИНҮТ ТӨХХК-ын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах;
 - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх;

- Арга хэмжээнүүдийг “дэмжлэг үзүүлэн ажиллах, хамтран ажиллах, нягт холбоотой ажиллах” гэх мэтээр хэмжих боломжгүй, ерөнхий байдлаар томъёолохгүй байх;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР